



# Барилгын Талбай Дээр

Монгол улс өөрчлөгдөж байна. Мэдээжийн хэрэг, Монгол улс сүүлийн хорь гаруй жилийн турш хурдтайгаар өөрчлөгдсөөр байсан ч, саяхнаас шинэ шатанд шилжиж байгаа тухай Их Британи улсын Гаардиан (eng.Guardian) сонин “хүн төрөлхтөний түүхэнд гарсан хамгийн том дэвшлүүдийн нэг гэж хэлж болохоор хувьслын ирмэг дээр ирсэн”<sup>1</sup> гэж тодорхойлжээ. Нэгэн үед дээдлэгддэг байсан Монголын хөрс шороог сэндийлэн, нүүрс, зэс болон ураныг ухан гаргаж байгаа энэ уул уурхай нь яагаад ингэж их анхаарал татна вэ. Хөгжиж байгаа эдийн засаг нь ихэнх хүмүүсийн амьдралын түвшинг дээшлүүлж байгаа хэдий ч, олон хүн энэ үйл явцыг хэт дэмжих болон шүүмжлэхээс түдгэлзэж байна. Энэ нь сайн ч биш, муу ч биш, зүгээр л бодит байдал. Өөрчлөлт. <sup>2</sup>

Би Монголд анх долоон жилийн өмнө бүлэг уран бүтээлчдийн хамт, өөрсдийн ертөнцийг үзэх үзлийг дахин тодорхойлох хүсэлдээ хөтлөгдөн, Европоос тэс өөр орныг бид яаж хүлээн авах бол гэж сонирхон хүсэн ирсэн юм.<sup>3</sup> Бид харийн соёлтой танилцахаас гадна өөрсдийгөө харийн хүн мэтээр мэдрэхийг хүссэн билээ. Бид хүссэнээ мэдэрсэн боловч энэ үйл явц нь олон жилийн турш үргэлжлэн, янз бүрийн хэлбэртэй явагдсан бөгөөд, энэ үеэр Монгол хувьсан өөрчлөгдөж, бид ч бас хувирсан юм. Сайн тал руугаа юм уу, муу тал руугаа өөрчлөгдсөн эсэхийг хэн хэлж мэдэх билээ?

Хэрвээ бид нар энэ өөрсдийн сонгосон амьдралын замаараа яваагүй бол одоо ийм хүмүүс болохгүй байх байсан. Ницше *Ессе Homo* гэдэг зохиолдоо, “хүн өөрийнхөө төсөөлсөн шигээ л хүн болдог, яагаад гэхээр хүн өөрийгөө хэн гэдэг тухай ямар ч ойлголтгүй байдаг болохоор”. “Амьдралын зовлон бэрхшээлүүд, туслах замууд болон буруу эргэлтүүд”-ийг урьдчилан харж, зайлсхийвал хүний туулах амьдралын процесс нь утгагүй болох нь ойлголмжтой. Магадгүй, хамгийн цэцэн ухаан нь бидэнд тохиолдсон тэр азгүй тохиолдлуудаас үүдэн бий болдог - “тэдгээр нь олж авсан ухааны илэрхийлэл юм”.<sup>4</sup>

1 Гаардиан сонин: <http://www.guardian.co.uk/environment/2011/nov/07/gobi-mega-mine-mongolia>.

2 Энэ эссений нэг хэсэг нь Цаг хугацаа, Орон зай болон Эрчимт байдал дунд Аялах нь (eng.Travels in Time, Space and Intensity, /2012.

3 Вилениусийн эмхтгэсэн Нүцгэн Байшин: Пори-Роттердам-Улаанбаатар номонд бас хэвлэгдсэн, 2011.

4 Ницше: *Ессе Homo*, 1980, х.64.

Өөрийгөө таньж мэднэ гэдэг нь урагшаа хандсан чиглэлтэй гэхээсээ буцан эргэх чиглэлтэй байсан нь тохиромжтой. Бид тэр амьдралын ямарваа үзэгдлийг туулах явцдаа бүх анхаарлаа түүнд хандуулан, зөвхөн болсны дараа нь эргэцүүлэн бодох нь зүйтэй.

Яг үүнийг *Нүцгэн байшин. Пори-Роттердам-Улаанбаатар* нэртэй үзэсгэлэн солилцооны төсөл өөрийнхөөрөө хийх гэж оролдсон юм. Хүн, байршил, соёлын солилцоо явагдаж, тэдгээртэй хамт, бүтээл хийх болон олон нийтэд хүргэх аргачлалуудыг ашиглан бид “өөрийгөө олох” зорилготой хагас-этнографийн маягтай бүтээлч явцыг Монгол Европийн хооронд бий болгосон юм. Энэ хэвлэл нь 2011 онд Улаанбаатар хотын Занабазар Музейд зохион байгуулсан үзэсгэлэнгийн тухай баримтжуулах болон эргэцүүлэх зорилготой.

### **Аян Замын Нүцгэн Байшин**

Анхны *Нүцгэн Байшин* үзэсгэлэн нь 2010<sup>1</sup> онд Финлянд улсын Пори хотод зохион байгуулсан бөгөөд ихэнх бүтээлүүд нь Пори хотын түүх болон газарзүйтэй уялдуулан, тухайн байршил дээр бүтээсэн. Бүх оролцогчид нь Пори-Уран Бүтээлчийн резидэнс хөтөлбөрийн хүрээнд ажилласан бөгөөд, Монголоос ирсэн 2 уран бүтээлч Нидерландын Роттердам хотод резидэнс хөтөлбөрт бас хамрагдсан байсан. Энэ үзэсгэлэн төслийн хоёр дахь хувилбарыг бид Улаанбаатар хотод хийхдээ Монголын хэд хэдэн уран бүтээлчийг нэмж оролцуулж, шинээр бүтээлүүдийг хийж, Порид хийсэн бүтээлүүдээс цөөн хэсгийг нь үлдээж, өөр маягаар засаж, Монгол орчуулгатай болгосон. Зарим бүтээлүүдийн хувилбаруудыг харж байхад, ижилхэн бүтээлүүд (бараг) өөр байршилд үзүүлэхэд утга санаа нь хувирч байгаа нь их сонирхолтой байсан.

Уран бүтээлч С.Ганзүг тавин ямаанаас бүрдэх *Ямаануудын Музей* бүтээлээ Финляндад хийх гэсэн боловч ямааны тоо бүрдээгүйгээс хийж чадаагүй бөгөөд Монголын музейд бас хийж чадаагүйдээ их гайхаж байсан. Энэ удаад ямааг олох нь асуудал биш байсангүй, харин тус музейн дотоод журам ямааг музейд оруулахыг зөвшөөрөхгүй байв. Музейн удирдлага ямааг гадаа талбайд байрлуулахыг санал болгосон юм. Ямааг гадаа байрлуулах нь тухайн бүтээлийн гол санааг гаргах боломжгүй болгох байлаа. С.Ганзүгийн өөр нэгэн бүтээл нь Монголын баруун аймагт байрлах өөрийн нутгийн сумын төвд нугалсан цаасаар хийсэн салхин тээрмүүдийг модон саваан дээр хатгаж буй перформанс юм. Сумын төвийн цахилгааны гол модыг тойруулан тавьсан энэ хүүхдийн юм шиг тоглоомууд нь энергийг нүүрс болон модноос гадна өөр бусад эх сурвалжаас олж болно гэдгийг

---

5 Вилениусийн эмхтгэсэн Нүцгэн Байшин: Пори-Роттердам-Улаанбаатар номонд бас хэвлэгдсэн, 2011

сануулж байна гэж ойлгож болох юм. Түүний энэ бүтээл нь хүмүүсийн анхаарал болон шүүмжлэлийг зэрэг тагаж байна. Энэ бүтээлийн баримтжуулсан хэлбэрийг музейд тавьсан боловч бүтээлийн утга санаа хувийн шинж чанартай юм уу эсвэл улс төрийн хандлагатай гэж ойлгогдохооргүй байв.

Европын болон Монголын гэр, орон сууцны тухай эргэцүүлсэн бас нэг бүтээл нь Катрин Хорнекийн *Хэрвээ Уран Барилга Ярьж Чаддаг Байсан Бол* юм. Хоёр сувагт энэ видео инсталляц нь Австрийн орон сууцны талаарх дүрэм журамд баригдахгүй, жинхэнэ эрх чөлөөг Монгол гэр барих замаар олж авахыг хүсэж байгаа Австричууд - гэр хороололд амьдардаг иргэд болон талын нүүдэлчид орон сууцанд амьдарвал ямар эрх чөлөөг амсаж болохыг мэдэхийг хүссэн Монголчууд нарыг зэрэгцүүлэн харуулсан. Энэ бүтээл нь Монголын уламжлалт болон футурист соёлыг холбосон нь Монголын үзэгчдийн сонирхлыг ихэд татсан юм. Монгол орчуулгатай болгож шинэ хувилбараар гаргасан бас нэг бүтээл бол миний өөрийн *Миний Өссөн Байшингаас...Хелсинк-Улаанбаатар* нэртэй. Би Улаанбаатарын эргэн тойрон дахь гэр хорооллын зургийг авч, өөрийн бага насаа өнгөрүүлсэн хүрээлэн буй орчны тухай өгүүллүүдтэй уялдуулж өгсөн. Гэвч энэ хувилбар нь Монголын үзэгчдийн анхаарлыг нэг их татсангүй, магадгүй тэдэнд хэт энгийн эсвэл харийн санагдсан байж мэднэ.

Уран бүтээлийн олонд хүртээл болгох байршлыг солих нь түүнтэй холбогдох агуулга өөрөөр ойлгогдох шалтгаан болох боломжтойг Манчестер хотод болсон Азийн Триеннальд урилгаар оролцсон Т.Энхболдын бүтээлийг соёлын үүдэлтэй хэд хэдэн ташаа ойлголтууд бий болсон тухай жишээ болгон ярьж болох юм. Түүний перформанс бүтээл нь Улаанбаатарт болсон үзэсгэлэнгийн нэг хэсэг байсан бөгөөд Манчестерт хийсэн түүний перформанс бүтээлийг видео хэлбэрээр мөн баримтжуулан тухайн үзэсгэлэнд тавьсан. Энхболдын бүтээл болон бүтээлийн ‘үндэс’ хоёрын хоорондох холбоосын тухай асуулт асуусан байна. Фийби Чамбр бичихдээ, “Энхболдын бүтээл нь түүний төрж өссөн нүүдэлчин соёлтой шууд холбоотой боловч, хэрвээ Монголын хөдөө нутагт энэ перформанс бүтээлээ хийвэл, урлаг гэж хэлэгдэхгүй. Энхболд (дотоод зөрчилтэйгөөр) хотожсон байршлаас байршил руу эсгэж энэ перформанс бүтээлээ байрлуулж хийснээрээ “урлаг” гэж амьдруулж байх шиг.”<sup>42</sup>

---

2 Фийби Чамбр: Тогмидшийрэвийн Энхболдын Зүүлүн Уриа, The Manunion сэтгүүл, <http://www.student-direct.co.uk/2011/11/16/enkbold-togmidshiirevs-gentle-message/>, 2012 оны 7-р сарын 21-нд уншив.

Энэ эргэцүүлэл нь сонирхолтой - хөдөөний нүүдэлчин байтугай энгийн Монгол хүн Энхболдын бүтээлийг хараад тэдний өдөр тутмын зан үйлийн нэг хэсэг гэж үзэхгүй нь тодорхой тул - тэр бүтээл нь хөдөө нутагт “урлаг” биш байх өөр ямар шалтгаан байж болох вэ? Хөдөөний хүмүүсийн урлагийн талаарх ойлголт муутай байдал уу? Нүүдэлчдийн талаарх энэ эргэцүүллийг сөргүүлэн бодоход, Манчестерийн Музейн дотоод журмын дагуу энэ “нүүдэлчин” перформанс бүтээлд тавьсан олон хязгаарлалтын тухай бас дэлгэн үзүүлсэн бол их сонирхолтой байх байсан юм шиг. Тэр хязгаарлуулалтуудаас нь дурдвал, нүцгэлж болохгүй, морины хомоол хэрэглэж болохгүй, ямар нэг юм шатааж болохгүй, боловсруулаагүй амьтны арьс хэрэглэж болохгүй гэх мэт. Энэ хоёр перформансыг зэрэгцүүлэн тависан бол бүтэн биеийн цагаан өнгөтэй комбинзон өмссөн, Европын журамд тохирсон, хүүхдэд халгүй материалыг ашиглаж, хүүхдэд халгүй үйлдэл хийсэн “музейн нүүдэлчин”-ийг бүтээснээс илүү хүчтэй бүтээл болох байсан байж мэднэ. Энэ шүүмжлэлээс ямар санаа дугааж байна вэ гэхээр Энхболдын нүүдэлчний дүрийн тоглолт нь тухайн цаг хугацаанд хамгийн их сонирхлыг татаж байгаа үзэгдлийг дагадаг Европын урлагийн ертөнцийн хүрээнд ашиглагдсан эсвэл тэрээр санаатайгаар ашиглуулснаас хамаарахгүйгээр, Монгол нь төрөлх байдлаа хадгалсан (хэсэгчилсэн) гайхамшигтай орнуудын нэг юм.

Бас нэгэн сонирхолтой соёлын утга нь алдагдсан үзэгдэл болсон нь Алетта де Жонгийн *Модернизмын Эргэн Тойрныг Тохижуулах* нь инсталляц бүтээл юм. Энэ бүтээл нь хаягдал дахин боловсруулах болон өөр зорилгоор дахин ашиглах тухай бөгөөд Барууны хэрэглээг шүүмжилсэн, эргэцүүлсэн хандлагатай: Дани улсад байдаг төмрийн хаягдлаас бүтсэн уул болон хуванцар саванд дотор суулгасан байгалийн эмийн ургамлын гэрэл зургуудыг ашигласан. Тухайн инсталляцын байршил дээр бид цугларч Монгол явах төлөвлөгөөгөө цуцалсан, Монголыг огт үзээгүй Алеттаттай байлцсан. Тааралдсан материалаа ашиглаж бүтээл хийх нь сая жилийн биш юмаа гэхэд хэдэн зуун жилийн турш хэрэглэгдэж урлагийн бүтээл хийх ирсэн аргачлал бөгөөд хотжилтын сүүл үеийн энэ Европын санааг ийн үзүүлсэн нь тухайн аргачлалыг мэддэг хүмүүст зааварласан мэт санагдахааргүй байлаа. Харин, энэ бүтээл нь нэг тасарсан холбоос байгааг нь харуулж байна: шинэ-болгоныг-дандаа-хаях соёлыг дахин эргэцүүлэх шаардлагатай гэсэн радикал уриа нь олонхын саналыг арай аваагүй байна. Бүтээл нь хоёр соёл болон байрлалыг хооронд нь гайхалтайгаар уялдуулсан

байсан боловч, оршин суугчдын ёс зүйн үүднээс сэтгэлийг нь татсан бүтээл гэхээсээ илүү гоо зүйтэй болсон гэж хэлж болох юм. Мэдээж, үүнд хөгжиж буй орны “хөгжлийг бууруулах буюу сааруулах” хандлагыг толгойлон дэмжих нь бага зэрэг эвгүй сэтгэгдэл төрмөөр юм шиг. Бүтээлийг хийж байхдаа солилцсон бидний өрөөсгөл ойлголтууд болон тайлбарууд нь Монголыг огт үзээгүй тохиолдолд төсөөлөн бодоход үнэхээр хэцүү гэдгийг батлан харуулсан юм. Ийм маягын, бүтээлийг хийх болон дэлгэн үзүүлэх үзэгдлүүд нь нийгмийн болон материаллаг нөхцлүүдийг өөр соёлын утгад хамааруулан хамтад нь авчирснаар урлагийн мэдрэмжийг бий болгох, урлагийн тухай харилцан яриа, мэтгэлцээнийг өдөөн бий болгох хүчин чадалтай гэдгийг илэрхийлж байна.

### Өөрчлөлтийн салхи

Би тэдгээр солилцооны тухай өөрийн туршлагаас эргэцүүлж байна. Миний өмнө хэлсэнчлэн, 2005 онд Монгол явах анхны санаа маань өөрсдийн дасаж дадсан орчноосоо маш өөр ертөнцийг үзэх байсан бөгөөд бид түүнийг үнэхээр мэдэрсэн. Эхэндээ, бид нар энэ хоёр гурав сарын хугацаатай аялалыг адал явдал гэж үзээд хэцүү, бэрхшээлтэй зүйлсийг тэвчдэг байлаа. Би Монголын амьдралд дасаж, бараг Монгол болж байгаадаа (Монгол хэлгүйгээр) их баяртай байлаа.

Аажмаар, би гэр хорооллоор явж, хүмүүстэй уулзаж, тэдний бага насны дурсамжыг сонсон, дуусашгүй их сүүтэй цай ууж, шорлог болон шар айрагтай цэнгээнд уригдаж явах явцдаа – би 1970-аад оны Хелсинкийн эмх цэгц багатай, зэрлэгдүү гэмээр дүүрэгт өнгөрүүлсэн бага настай минь маш төстэй санагдсан юм. Мөн Монголын хөдөө нутаг надад гэртээ байгаа юм шиг л сэтгэгдэл төрүүлсэн. Хувийн орон зай багатай, цэвэрч байдлыг байнгын хадгалах боломжгүй нүүдэлчин амьдралын түвэгтэй гэж хэлж болохоор талууд нь миний сэтгэлийг зовоодоггүй байлаа. Монголын Их Эзэнт Гүрэн байгуулагдсаны 800 жилийн ойн баяр наадмаар, Сүхбаатарын талбай дээр зогсож, Скорпион (eng. Scorpion) хамтлагийн *Өөрчлөлтийн Салхи* (eng. *Wind of Change*) дууг амьдаар сонсон, хуванцар савнаас архи уун баясаж зогсож байхдаа, надад ямар нэг гомдоллох шалтгаан байсангүй.<sup>1</sup>

---

<sup>1</sup> Скорпион хамтлагийн Өөрчлөлтийн Салхи (eng. Wind of Change) нь 1989 оны Берлиний ханыг буулгах үеийн дурсамжит дуу юм. Энэ үйл явдалтай тохиолдуулан Сүхбаатарын талбай дээр болсон жагсаалууд нь Ардчилсан хувьсгал болж хувирсан бөгөөд гурван сарын дараа дэлхийн хоёр дахь Коммунист засаглал огцорсон билээ. Надтай хамт тоглолтыг үзэж байсан найзууд маань энэ дуу 15 жилийн өмнө чухал байсан боловч, одоо бол...тиймэрхүү...

Үүний дараа би *Нүцгэн Байшин* төслийн сүүлийн үзэсгэлэнг зохион байгуулахаар Монголд ирлээ. Би зургаан сар байх хугацаандаа хоёр үзэсгэлэн зохион байгуулах, санхүүжүүлэх зорилготой байсан боловч, тухайн музей нь “үзэсгэлэнг байгуулах” гэдэг ойлголт дутмаг байсан. Музейн хувьд, үзэсгэлэн гаргана гэдэг нь утсаар дүүжлэн бүтээлийг өлгөөд л болоо гэж үздэг бөгөөд хэдхэн цагийн дотор үзэсгэлэн бий болдог гэж боддог. Музейн маркетинг болон ажиллах цагийн тухай гэх гайхширмаар мэдээлэлтэй бид тулгарч байлаа. Мэдээжийн хэрэг, Буддын шашны үнэт бүтээлүүд хадгалдаг музей нь орчин үеийн урлагийн музейг бодвол хэд хэдэн асуудалтай байх нь ойлгомжтой юм. Ямарваа бүтээлийг урлагийн бүтээл болгож харагдуулах нь газарзүйн болон тухайн нөхцөл байдлаас маш их шалтгаалдаг. Энэ бүх нөхцөл байдал дээр нэмэгдэн хэт хурдацтай өргөжиж буй Улаанбаатар хотын тээврийн түгжрээ, дугаарлах нь тэсвэрлэхийн аргагүй болсноор – миний Европ-Веберийн сэтгэл зүй нь Монголын энэ нөхцөл байдалд дасах гэсэн хандлагыг зогсоосон юм. Тэр үед, би өөрийгөө “бүртгэлтэй харийн хүн” гэдэг хууль ёсны нэр томъёотой яг нийцэж байгааг бүрэн мэдэрсэн юм.

Монгол болон Улаанбаатар хотыг эмх цэгцгүй, замбараагүй гэсэн ойлголтыг авах – бас тийм ойлголтыг бусдад өгөх их амархан. Нэг талаараа, энэ нь үнэн юм. Жишээлбэл, Монголын соёлд урьдчилсан төлөвлөх гэдэг нь маш өөр утгатай. Энэ асуудалд нүүдэлчин дараах байдлаар хандаж болох юм, “Одоо санаа зовоод яах юм бэ? Маргааш гэхэд бүх юм өөрчлөгдөх юм чинь”<sup>1</sup>. Гэхдээ миний бодлоор, Монгол улсын хувьд зах зээлийн эдийн засаг болон тээврийн түгжрээ гэх мэт эмх цэгцгүй, замбараагүй байдалтай байгаа ч, бодит байдал дээр хэрэгждэггүй онолын тогтолцоотой нөхцөлд тухайн тогтолцоонд хүмүүс үнэнчээр, санаачлагатайгаар хамрагдана гэдэг нь боломжгүй зүйл гэдгийг сайтар ойлгох нь чухал юм. Энэ тогтолцооны нэг нь шашин бөгөөд Монголын хувьд энэ шашин нь Ламаизм, бөө болон Буддын шашны холимог бөгөөд – ихэнх Монголчууд өдөр тутам энэ шашныг эрхэмлэн шүтдэг.

Ямар нэг зүйл төлөвлөхөөс эхлээд хүүхдийн үс авах хүртэл, өглөөнөөс үдэш хүртэл хийгдэх үйлдэл бүр ямар нэг ёс заншилтай холбоотой байдаг ба энэ тухай ламтай заавал зөвлөлдөх хэрэгтэй. Замбараагүй мэт давхилдах тэр олон машинууд нарны эрчим хүчээр ажилладаг мөргөлийн дугуйгаар гоёсон байдаг.

---

1 Хампри & Снийф: Нүүдэлчний Иргэншил Төгсгөл Болсон уу?, 1999, х.306.

Үүнээс гадна, өөрийн гэсэн эд зүйлээ үүрээд, хээр талаар зорилгогүй давхих гэсэн ойлголтоос тэс өөр нүүдэлчний соёлын хүчтэй тогтолцооны нөлөө мөн харагддаг. Гэр дотор бүх зүйл өөрийн гэсэн байрлалтай, гэр бүлийн гишүүн бүр өөрийн гэсэн хэсэгтэй. Гэрээ заавал хэрэгтэй газар руу зорилготой нүүнэ. Энэ бүхний дээр нь Монголыг илэрхийлэх гол ойлголт бол гэр бүл юм. Тэгэхээр өнөөгийн Монголын энэ эмх цэгцгүй, замбараагүй байдал нь хүн төрөлхтөний түүхэн дэх хамгийн гэнэтийн өөрчлөлтийн улмаас болж байна уу? Хүн бүр үүнийг мэдрэх нь аргагүй юм.

### Хоосон Төсөөллүүдийн Хот

Би гэртээ буцан ирж, өөрийн адал явдлаа профессор Тайна Ражанти-д (*Нүцгэн Байшин* төсөл миний докторын ажлын нэг хэсэг<sup>2</sup>) өгүүлэн ярьсан бөгөөд, тэрээр Урсула К. Ле Гүйн шинжлэх ухааны хийсвэр зохиол болох *Хоосон Төсөөллүүдийн Хот* гэдэг зохиолыг уншиж үзээч гэж санал болгосон юм. Тэрээр энэ номыг надад сонирхолтой байх болов уу, яагаад гэвэл шинэ соёлд нэвтрэн орохын тулд чи ганцаараа, бас харийн хүн байх хэрэгтэй гэсэн утгыг илэрхийлдэг гэж хэлсэн. Хэрвээ чи хоёулаа бол, хоорондоо нэгдэж, үүрд харийн хүмүүс хэвээрээ үлдэнэ. Би тэр зохиолыг гайхан, шимтэн уншиж байх явцдаа, түүний утга санаа нь илүү гүн гүнзгий гэдгийг ухаарсан.

*Хоосон Төсөөллүүдийн Хот* зохиол нь сүүлд Фалк гэдэг нэртэй болсон хоёр мянган жилийн өмнө амьдарч байсан харийн хүний тухай юм. Тэрээр өөрийн ой ухаанаа алдсан ба хэн түүнийг хаанаас ирсэн гэдгийг мэддэггүй байжээ. Нутгийн олон түүнд өөрийн хэл, соёл, ур чадвар болон итгэл үнэмшлийг зааж сургасан байна. Тэрээр нутгийн олны нэг болсон боловч, түүний ой ухаанд нэгэн уулын бүдэг бадагхан дурсамж байдаг тул – өөрийгөө хаанаас ирсэн тухайгаа мэдэхийг хүсэн аялалд гарчээ. Дэлхий Шинг гэдэг нэртэй үндэстний удирдлага дор байдаг. Фалк Шинг үндэстний хотод ойртох тусам, тэрээр олон хувилбарт үнэнтэй тулгарч байсан ба бодит хүнтэй ярьж буйгаа, эсвэл төсөөллүүд, хоосон төсөөллүүдтэй харьцаж байгааг ялгах боломж байхгүй байлаа.

Шинг үндэстний хотод Фалк өөрийгөө харь ертөнцөөс ирсэн ба түүний ой ухаан арчигдсан тухай мэдэж авжээ. Нэгэн Шинг Фалкад хэлэхдээ, түүний хуучин

---

2 Хагас-бөөрлөсөн Гэртэй Цэцэрлэг: Бие Хүн, Олон Нийт, Эргэн Тойрны Тухай Сэтгэгдлийг Монголын Хотжитын Үйл Явцаар Туулах нь (eng. Semi-detached Ger with a Garden: Experience of Self, Community and Environment through Urbanizing Mongolia ) уран бүтээлийн үзэсгэлэнг судалгааны хэлбэр болох тухай, Дүрслэх урлаг, Дизайн, Уран барилгын Сургууль, Аалтогийн Их Сургууль.



ой ухааныг сэргээж болно, гэхдээ түүний одоо байгаа ой ухаан, дурсамж, бие хүнийг байхгүй болно гэжээ. Мэдээж, Фалк тийм замыг хүссэнгүй – тэгээд өөрийн бүтээсэн бясалгалт үйлдлээр өөрийн хуучин бие хүнийг шинэ бие хүнээр дамжуулан олохыг хүссэн байна. Тэрээр тэгж чаджээ. Эхэндээ, тэрээр хоёр бие хүнийг агуулсан биеэ удирдаж чадахгүй галзуурахаа шахсан боловч, аажмаар тэнцвэрийг олсон байна. Өөрийн энэ гайхалтай хүчин чармайлтын хүчээр, тэрээр хоёр бие хүнийг нэг мэт удирдсанаар Шинг хотоос сансрын машин хулгайлан оргож, өөрийн ертөнц рүү нисжээ.

Миний бодлоор, энд юу чухал вэ гэхээр, Фалк өөрийн хоёр бие хүнийг, тэдгээрт байгаа өөр шинж чанаруудыг, мэдлэг ур чадварыг хамтад нь болон ээлжилж ашиглаж чаддаг байдалд байгаа гэж бодож байгаа. Түүний хуучин бие хүн нь зуун дөчин гэрлийн хурдаар сансарт нисдэг хөлгийн тохируулгыг хийж чаддаг сансрын одон орон судлаач байсан бол, Дэлхийн шинэ бие хүн нь оргохын тулд гаргаж болох аргыг сурсан байлаа. Энэ зохиол нь холимог үнэн ялан дийлж дэлхий ертөнц амар тайван болдог гэсэн маягаар дуусгавар болж төгсдөггүй. Өөрийн хоёр бие хүн болон хоёр өөр амьдралын туршлагаас гадна, Фалк-Рамаррен гэдэг нэртэй болсон хүн маань, гайхсан Шингийн удирдагч, Шингийн уриаг түгээгч маягаар бэлтгэсэн залуу харийн хүн хоёрыг гэртээ аваачиж, тэд нар одоо Дэлхийн тухай хамгийн багаар гурван янзын хувилбарыг (үнэнийг) мэдэж байна гэж дүгнэдэг.

Өөрөөр хэлбэл, *Хоосон Төсөөллүүдийн Хот* нь өндөр технологи, сэтгэлийн хүч болон санаандгүй тохиолдол гурваас улбаалан нэг ухаан санаа нь тэс өөр хоёр бие хүн, соёлыг агуулж чадахыг харуулсан зохиол юм. Мөн энэ зохиол иймэрхүү маягын хослох явц нь (аль аль хэсгүүдийг хадгалан) ертөнцийг удирдахад чухал гэдгийг илэрхийлсэн. Ерөнхийдөө, технологи болон ертөнцийг үзэх үзэл биднийг удирддаг болох тухай, тэдгээрийн янз янзын хувилбар нь өөр хороондоо ялгаатай үр дүнг өгдөг гэдгийг хэлсэн байна. Миний бодлоор, энэ зохиол нь би болон бусад уран бүтээлчид, судлаачдын (хотожсон) Монголын нүүдэлчин болон Буддын соёлыг шинэ технологийн хослол гэж байх боломжтой гэдэгт итгэсэн, бэлэн байгаа сонголтуудаас зайлсхийх санааг бас гаргасан юм шиг санагдсан.

## Өөртөө Харийн Хүн Байх нь

Би өөрийн энэ өгүүлүүдээр юу хэлэх гээд байгаа вэ гэхээр, энэ төслөөс үүдсэн олон янзын туршлага, мэдрэмжүүдийг бусдад (хүмүүс, соёлууд, хотууд)<sup>1</sup> болон бидэнд бий болгосон юм. Бидэнд хамааралтай болон хамааралгүй зүйлс, байршлууд нь өөр үе шатанд, өөр байдлаар харагддаг. Бид ямар нэг шалтгаанаар, бидний хувь хүн маань бөх бат, бүрэн бүтэн гэж ойлгодог боловч тийм биш юм. Бид хуваагдмал. Бид байнга өөрчлөгдөх үйл явц. Бид өөрчлөгддөг. Энэ тухай Жулия Кристева бидний дотор орших харь хүн нь, бидний ухаан санаанд мэдэгдэхгүй, бидэнд мэдэгдэхгүй тэр хэсэг нь бидэнд хамааралгүй (ямар нэг байшинд, соёлд) гэж оновчтой тайлбарласан байдаг. Тэрээр, өөрсдийн дотоодод байдаг болон бусдад байдаг харийн шинж чанарыг хүлээн зөвшөөрдөг шинээр бий болж буй харийнхны бүлэглэл нь – “радикал харийн шинж чанар”-ын тухай энэ хосолсон мэдлэгийг ашиглан, бид өөр нэг чиглэл рүү хандаж мэднэ.<sup>2</sup> Бид тэгэхээр эерэг үгүйсгэх үзлийг (нихилизм) хайж байна уу?<sup>3</sup> Өөрийгөө булаалгасны дараа, тэгээд юу өөрчлөгдөх боломжтой тухай бодох, тэнд юу байгааг олж харахын тулд Барууны болон Монголын өөрийншил (бие хүмүүс, гэр бүлүүд), урлагийн дадлага, этнограф, хотын судалгаа зэргийн хосолмол хувилбаруудыг бий болсон. Олон ургальч үзэл болон ялгаатай байдлын чухлыг онцлоод, Жэйн Рэнделл Кристевагийн гаргасан нэр томъёо болох “хошуулдсан тэнхлэг” (eng. diagonal axis)-ийг интердисциплинари (eng. interdisciplinarity) буюу олон салбарын холимог чанарын тухай маргааны гол асуудал болгон авч үздэг ба энэ нь мөн олон улсын (eng. internationality) шинж чанартай юм. Энд юу чухал вэ гэхээр, өөрсдийн байгаа мэдлэгийг үгүй болгоход бэлэн байж, тэр үл мэдэгдэх газар нутгийг (зан үйлдлийг) мэдэхийн тулд аялах нь “интердисциплинари бүтээлээс бий болсон том өөрчлөлтийн мэдрэмж нь давамгайлсан хүчнүүдийн харилцаанд орсноор шинэ буюу тодорхой бус мэдээллийг бий болгох нөхцлийг бүрдүүлж байна.”<sup>4</sup>

1 Кристева, 1991, х.192

2 195-р хуудастай адил.

3 Эерэг нихилизм гэдэг нь төрмөл бус үнэлгээний хэлбэрүүдийг (бусдыг буруушаан шүүмжлэх, ангилал, нийгмийн олонхын сэтгэлгээ гэх мэт) үгүйсгэснээр төрмөл үнэт чанаруудыг гаргаж ирэх, дахин бий болгохыг хэлж болно. Эерэг нихилизм нь зөвхөн Ниццийн үзэлтэй холбоотой биш бөгөөд Паганы соёл, шашингүйн үзэл, Буддизм, Хинду шашин зэрэг нь үүнтэй төстэй хандлагатай байдаг. (The Unpopular Truth, 2008 Online: <http://penetrate.blogspot.fi/2008/11/nihilism-in-search-of-working.html> accessed 6 Au 2012, David Storey 2011).

4 Жэйн Рэнделл: Орон Зайн Шүүмжлэлт Дадлага: Кураторлах, Эмхэтгэх, Бичих, Intellect, Bristol and Chicago, 2007, х.60.

Рэнделл, Кристева нар энэ үйл явц нь зөвхөн оюун ухааны болон шүүмжлэлт биш, мөн сэтгэл зүй болон улс төртэй холбоотой гэдэг дээр санал нийлж байна. <sup>1</sup>

Ницшег дагахын тулд: хүн өөрөө өөрийгөө шалгаж, сорьж байх хэрэгтэй, өөрөө шинэ ертөнцийг олох хэрэгтэй – амьдралын шинэ боломжийг олох, барилгын шинэ талбай бас олох хэрэгтэй.

Анну Вилениус

Арабиа, Хелсинк

2012 оны 7-р сарын 1

Орчуулагч Цэгмэдийн Цэндпүрэв

---

<sup>1</sup> Өмнөх ишлэлтэй адилхан.

## **Ашигласан материалууд**

Хааклин, Саара & Вилениус, Анну [эмхтгэсэн]: *Монгол: Ойлгоц болон Төгс Ертөнц*, 2008

Хампри, Каролайн & Снийф, Давид: *Нүүдэлчний Иргэнийл Төгсгөл Болсон уу?*, 1999

Кристева, Жулия: *Өөртөө Харийн Хүн Байх нь*, 1991

Ле Гүйн, Урсула К: *Хоосон Төсөөллүүдийн Хот*, 1967

Ницше, Фридрих: *Ессе Ното*, (1888) 1980

Жэйн Ренделл: *Орон Зайн Шүүмжлэлт Дадлага: Кураторлах, Эмхэтгэх, Бичих*, 2007

Вилениус, Анну [эмхтгэсэн]: *Нуцгэн Байшин: Пори-Роттердам-Улаанбаатар*, 2011